



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар A/60


Чингис хот

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаартай тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 43 дугаартай “Зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн зөвшөөрлийг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар, Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар хавсралтаар, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр хавсралтаар, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар хавсралтаар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР